Оптимизацийн бодлого, дасгалын хураамж

Р.Энхбат Д.Нямсүрэн М.Мэнд-Амар

Улаанбаатар хот
2005 он

1 бүлэг. Оптимизацийн сонгодог бодлогын тавил

1.1 Үндсэн ойлголтууд

Функцийн өгөгдсөн олонлог дээрх хамгийн их эсвэл хамгийн бага утгаа авдаг цэгийг олох бодлогыг оптимизацийн бодлого гэнэ. $f(x)$ функцийг X олонлог дээр минимумчлах бодлогыг

$$f(x) \to \min, \quad x \in X \tag{1.1}$$

гэж бичдэг. Энд f-ийг зорилгын функц, X-ийг боломжит шийдийн олонлог, $\forall x \in X$-ийг (1.1) бодлогын боломжит шийд гэнэ. Энэхүү номын турш бид төгсгөлөг хэмжээст бодлогууд үзэх бөгөөд өөрөөр хэлбэл бодлогын боломжит шийдийн олонлог нь Евклид огторгуй R^n дээр оршино. Хэрэв $x^* \in X \subset R^n$ цэгийн хувьд

$$f(x^*) \leq f(x), \ \forall x \in X \tag{1.2}$$

нөхцөл биелж байвал түүнийг $f(x)$ функцийн X олонлог дээрх глобаль минимумын цэг эсвэл (1.1) бодлогын глобаль шийд гэнэ. Хэрэв $x^* \in X \subset R^n$ цэгийн хувьд

$$f(x^*) \leq f(x), \ \forall x \in X \cap O_\varepsilon(x^*) \tag{1.3}$$

нөхцөл биелж байхаар ε тоо олдож байвал түүнийг $f(x)$ функцийн X олонлог дээрх локаль минимумын цэг эсвэл (1.1) бодлогын локаль шийд гэнэ. Энд $O_\varepsilon(x^*) = \{x \in R^n | \ ||x - x^*|| \leq \varepsilon\}$ нь x^* дээр төвтэй ε радиустай бөмбөлөг юм. Хэрэв (1.2), (1.3) нөхцлүүд нь $x \neq x^*$ хувьд эрс биелж байвал x^*-г харгалзан эрс глобаль, эрс локаль минимумын цэг гэж ярьдаг. $f(x)$ функцийг X олонлог дээр максимумчлах бодлого нь

$$f(x) \to \max, \ x \in X \tag{1.4}$$

гэсэн хэлбэртэй бичигдэнэ. Өмнөхтэй адилаар энэхүү бодлогын хувьд локаль, глобаль шийдийг тодорхойлж болно. (1.4) бодлого нь

$$-f(x) \to \min, \ x \in X$$

бодлоготой эквивалент бөгөөд иймд эдгээр бодлогуудын глобаль, локаль, эрс глобаль, эрс локаль шийдийн олонлогууд нь давхцана. Энэ нь бидэнд хүндрэлгүйгээр минимумчлах бодлогын хувьд яригдсан өгүүлбэрүүдийг максимумчлах бодлогын хувьд хөрвүүлэн ярих боломжийг олгоно. $f(x)$-ийн X олонлог дээрх максимум, минимумын цэгүүдийг нэгтгээд ерөнхий нэрээр экстремумын цэгүүд гэж ярьдаг. Түүнчлэн (1.1), (1.4) бодлогуудыг экстремаль бодлогууд гэнэ.

1.2 Глобаль шийд оршин байх нь

f функцийн X олонлог дээрх доод торгон зааг өөрөөр хэлбэл $f^* = \inf_{x\in X} f(x) = \inf_X f(x)$ хэмжигдэхүүнийг (1.1) бодлогын утга гэнэ. Энд гурван тохиолдол байж болно:

1. $f^* > -\infty$ ба ямар нэгэн $x^* \in X$ ийн хувьд $f(x^*) = f^*$ өөрөөр хэлбэл бодлогын утга зааглагдсан бөгөөд энэхүү утганд хүргэдэг цэг оршин байдаг.
2. $f^* > -\infty$ ба $f(x) > f^*$, $\forall x \in X$ өөрөөр хэлбэл бодлогын утга зааглагдсан боловч энэхүү утганд хүргэдэг цэг оршин байдаггүй.
3. $f^* = -\infty$ өөрөөр хэлбэл бодлогын утга зааглагдаагүй.

Эхний тохиолдолд (1.1) бодлого глобаль шийдтэй, харин (2) болон (3) тохиолдолд бодлого шийдгүй.

Теорем 1.1(Вейрштрасс) X олонлог нь R^n дээрх компакт(битүү зааглагдсан олонлог), f нь X олонлог дээр тасралтгүй функц байг. Тэгвэл (1.1) бодлогын глобаль шийд нь оршин байна.

$X \subset R^n$ олонлог дээр тодорхойлогдсон f функцийн хувьд эсвэл $\lim_{k\to\infty} x^k = x \in \bar{X}\backslash X$ эсвэл $\lim_{k\to\infty} ||x^k|| = \infty$ байх $\forall\{x^k\} \subset X$ дарааллын хувьд $\bar{\lim_{k\to\infty}} f(x^k) = \infty(\lim_{k\to\infty} f(x^k) = -\infty)$ нөхцөл биелж байвал түүнийг X олонлог дээр төгсгөлгүй өсдөг(буурдаг) дараалал гэнэ.

Теорем 1.2 X нь R^n дээрх дурын олонлог, f нь X дээр төгсгөлгүй өсдөг тасралтгүй функц байг. Тэгвэл (1.1) бодлогын глобаль шийд нь оршин байна.

1.3 Квадратлаг функц

$$f(x) =< Ax, x > + < b, x > +c = \sum_{i=1}^{n}\sum_{j=1}^{n} a_{ij}x_ix_j + \sum_{j=1}^{n} b_jx_j + c, \tag{1.5}$$

гэсэн хэлбэрийн функцийг квадратлаг функц гэнэ. Энд $A = (a_{ij})$ нь $n \times n$ хэмжээст симметр матриц, $b = (b_j) \in R^n$, $c \in R$.

Теорем 1.3 (1.5) квадратлаг функц нь эсвэл R^n дээр доороосоо зааглагдаагүй байна эсвэл R^n дээр глобаль минимумын цэгтэй байна. Хэрэв хоёр дахь нөхцөл нь биелэгдэж байвал A матриц нь сөрөг биш тодорхойлогдсон матриц ө.х. $< Ax, x >\geq 0,\ \forall x \in R^n$ байна.

Теорем 1.4 Хэрэв A матриц нь эерэг тодорхойлогдсон ө.х. $< Ax, x >> 0,\ \forall x \in R^n, x \neq 0$ байвал квадратлаг функц (1.5) нь R^n дээр төгсгөлгүй өсдөг бөгөөд $\forall X \in R^n$ дээр глобаль минимумын цэгтэй байна.

Теорем 1.5(Сильвестрийн шинжүүр) A матриц нь $n \times n$ хэмжээст симметр матриц байг. Тэгвэл

1. A матриц сөрөг биш тодорхойлогдсон байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь түүний бүх гол минорууд нь сөрөг биш байх явдал юм.
2. A матриц эерэг тодорхойлогдсон байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь түүний бүх гол минорууд нь эерэг байх явдал юм.

$x^0 \in R^n$ цэгийн $X \subset R^n$ олонлог дээрх проекц гэж X олонлогийн цэгүүд дотроос x^0 цэгт хамгийн ойрхон орших цэгийг хэлнэ. Өөрөөр хэлбэл проекц нь $f(x) = ||x-x^0||^2 \to \min,\ x \in X$ бодлогын глобаль шийд байна. Энд f нь $f(x) =< x - x^0, x - x^0 >=< x, x > -2 < x^0, x > + < x^0, x^0 >$ гэсэн нэгж матриц бүхий квадратлаг функц юм.

Теорем 1.6 $\forall x^0 \in R^n$ цэгийн битүү олонлог $X \subset R^n$ дээрх проекц нь оршин байна.

1.4 Оптимизацийн бодлогын геометр тайлбар.

Геометр байгуулалт нь оптимизацийн онолд чухал байрыг эзэлдэг. Эдгээр нь нэг талаас өгөгдсөн теоремын геометр дүрслэлийг харах бололцоог олгох төдийгүй нөгөө талаар хялбар оптимизацийн бодлогуудын шийдийг хайхад ашиг тустай байдаг. $X \subset R^2$ бүхий (1.1) бодлогын геометр дүрслэлийг харахын тулд хавтгай дээр X олонлог болон f функцын хэд хэдэн түвшний шугам гэж нэрлэгдэх $L_\alpha(f) = x \in R^2 | f(x) = \alpha,\ \alpha \in R$ олонлогуудыг зайлшгүй байгуулах шаардпагатай болдог. f функцын өөрчлөлтийн төлөв байдлыг харахын тулд өгөгдсөн түвшний шугамын α -аас их утга авч буй талд нь $+$ тэмдэг нөгөө талд нь $-$ тэмдэг тавих нь ашигтай байдаг. Бодлогын глобаль шийдийг олох бодлого нь түвшний шугам $L_\alpha(f)$ нь X олонлогтой хоосон бишээр огтлолцдог тийм α -уудаас хамгийн бага α^*ыг олох бодлого руу шилжинэ. Энэ үед $\forall x^* \in L_{\alpha^*}(f)X$ нь бодлогын глобаль шийд байх бөгөөд $\alpha^* = f^* = f(x^*)$ түүний утга байна. x^* шийд нь X олонлогийн дотор ч оршиж болно, гадна ч оршиж болно.

Дасгал

1.1.

$f(x) = (k-a)x + e^{(k-b)(k-c)x}$ функц R тэнхлэг дээр глобаль минимумын цэгтэй байх k параметрийн бүх утгыг ол. Мөн $f^* = \inf\limits_{R} f(x)$ утга төгслөг боловч энэ утганд хүргэдэг цэг R ээс олддоггүй байх k параметрийн бүх утгыг ол.

Хүснэгт 1.1.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	4	2	7	6	7	5	9	11	8	6	9	16	8	5	7
2	1	3	5	7	3	5	6	12	4	7	8	17	6	8	9
3	9	1	3	8	8	2	7	13	3	1	9	18	7	5	8
4	5	3	8	9	5	2	6	14	9	4	7	19	9	6	7
5	2	3	4	10	7	3	5	15	5	6	7	20	6	2	5

1.2.

$f(x,y) = kx^2 + 2axy + b^2y^2 + cx + my$ квадратлаг функц R^2 дээр глобаль минимумын цэгтэй байх $k,\ m$ параметрүүдийн бүх утгуудыг ол.

Хүснэгт 1.2.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	3	6	6	1	4	-2	11	5	2	15	16	4	3	16
2	1	8	-1	7	3	2	9	12	1	4	-3	17	5	6	-10
3	3	4	6	8	5	3	5	13	4	5	-4	18	3	4	-15
4	4	5	-8	9	2	5	-4	14	2	3	8	19	1	3	4
5	5	2	10	10	4	3	-12	15	3	7	6	20	2	5	-2

1.3.

Доорх $f(x,y)$ функцуудын R^2 хавтгай дээрх $L_\alpha = \{(x,y)|f(x,y) = \alpha\}$ түвшний шугамуудыг $\alpha = 0, 1, 2$ үед тус тус дүрсэл. а. $ax + by$ б. $ax^2 + by^2$ в. $ax^2 - by^2$
г. $ax^2 + by$ д. $a|x| + b|y|$ е. $a|x| - b|y|$
ж. $ax^3 + by^3$ з. $axy - bx^3$:

Хүснэгт 1.3.

	a	b		a	b		a	b		a	b
1	2	3	6	4	5	11	3	6	16	1	2
2	3	4	7	5	3	12	6	4	17	8	7
3	5	6	8	3	1	13	7	5	18	5	2
4	7	3	9	4	2	14	1	4	19	6	9
5	9	10	10	8	6	15	8	9	20	5	8

1.4.

R^2 дээр координатын эхийн $X = \{(x,y)|\ ax + by \geq c\}$ хагас хавтгай дээрх проекцийг ол.

Хүснэгт 1.4.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	1	3	6	1	-5	4	11	1	-2	1	16	5	-2	5
2	1	-3	1	7	4	1	5	12	2	4	2	17	-3	5	3
3	3	2	4	8	-2	3	1	13	-3	1	5	18	-5	4	2
4	-5	1	3	9	-4	2	2	14	1	4	3	19	5	3	4
5	4	-5	2	10	2	5	3	15	4	3	4	20	-3	4	1

1.5.

$(a,b) \in R^2$ цэгийн $X = \{(x,y)|\ x^2+y^2 \le c^2\}$ дугуй дээрх проекцийг ол.

Хүснэгт 1.5.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	3	5	3	6	-1	3	2	11	1	-4	3	16	-1	5	4
2	4	-1	4	7	6	-1	5	12	1	3	1	17	-2	5	2
3	5	1	5	8	-4	1	4	13	-5	4	5	18	-3	2	1
4	1	2	1	9	2	7	1	14	1	-2	2	19	7	-3	2
5	2	-3	2	10	5	2	3	15	3	-2	3	20	1	4	4

1.6.

$f(x,y) = x^2 + ay^2$ функцийн $X = \{(x,y)|\ |x| + b|y| \le c\}$ олонлог дээрх глобаль максимумын цэгийг ол.

Хүснэгт 1.6.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	3	2	4	6	5	3	2	11	2	1	3	16	6	2	9
2	1	2	3	7	10	3	4	12	1/2	1	2	17	1	2	4
3	5	2	2	8	1	4	1	13	4/5	1	1	18	5	2	5
4	2	3	4	9	3	4	2	14	12	3	6	19	20	5	10
5	1	3	3	10	20	4	3	15	8	3	4	20	30	5	20

1.7.

$f(x,y) = ax^2 - by^2$ функцийн $X = \{(x,y)|\ |x+1| + |y-c| \le 1\}$ олонлог дээрх глобаль экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 1.7.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	5	2	3/4	6	5	3	1/3	11	6	1	5/2	16	7	3	2/3
2	3	1	1	7	2	1	1/2	12	7	1	3	17	3	2	1/4
3	10	3	7/6	8	7	5	1/5	13	13	5	4/5	18	5	4	1/8
4	5	1	2	9	8	3	5/6	14	9	2	7/4	19	7	2	5/4
5	4	1	3/2	10	11	3	4/3	15	9	7	1/7	20	8	1	7/2

1.8.

$f(x,y) = ax - y$ функц $X = \{(x,y)|\ -x \le y \le kx + b|x| + c\}$ олонлог дээр глобаль минимумын цэгтэй байх k параметрийн бүх утгууд тодорхойлж, эдгээр цэгүүдийг ол.

Хүснэгт 1.8.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	6	3	5	6	4	2	2	11	8	2	4	16	6	1	3
2	7	2	2	7	7	3	3	12	10	4	1	17	9	2	1
3	8	4	3	8	9	4	5	13	4	1	5	18	5	1	2
4	3	1	1	9	10	3	4	14	6	2	3	19	9	3	5
5	5	2	4	10	2	1	1	15	8	3	2	20	10	2	4

Бодлого

1.1.

X дурын олонлог, f нь X олонлог дээрх дурын тоон функц, φ нь $U \subset R$ дээр өсдөг функц бөгөөд $f(x) \in U,\ \forall x \in X^*$ байг. Тэгвэл (1.1) бодлого нь

$$\varphi(f(x)) \to \min,\ x \in X$$

бодлоготой эквивалент болохыг батал. Өөрөөр хэлбэл эдгээр бодлогуудын эрс болон эрс биш глобаль эсвэл локаль минимумын цэгүүдийн олонлогууд нь харгалзан давхцдаг бөгөөд $\inf\limits_X \varphi(f(x)) = \varphi(\inf\limits_X f(x))$ болохыг батал.

1.2.

X нь дурын олонлог байг. X олонлог дээр тодорхойлогдсон дурын f функцийн хувьд $f^* = \inf\limits_X f(x)$ гэе. Тэгвэл дараах тэнцэтгэл болон тэнцэтгэл бишүүдийг батал.
а. $(\alpha f + \beta)^* = \alpha f^* + \beta,\ \forall \alpha,\ \beta \in R,\ \alpha > 0$
б. $(f+g)^* \geq f^* + g^*$
в. хэрэв $f^* \geq 0,\ g^* \geq 0$ бол $(f \cdot g)^* \geq f^* \cdot g^*$
г. $(\min\{f,\ g\})^* = \min\{f^*,\ g^*\}$
д. $(\max\{f,\ g\})^* \geq \max\{f^*,\ g^*\}$
е. хэрэв $f^* > -\infty,\ g^* > -\infty$ бол $f(x)g(x) + f^* \cdot g^* \geq f(x)g^* + g(x)f^*,\ \forall x \in X$.

1.3.

$f(x,y)$ функц нь $X \times Y$ декартын үржвэр дээр тодорхойлогдсон байг.
а. $\inf\limits_{X \times Y} f(x,y) = \inf\limits_X \inf\limits_Y f(x,y) = \inf\limits_Y \inf\limits_X f(x,y)$
б. $\sup\limits_X \inf\limits_Y f(x,y) \leq \inf\limits_Y \sup\limits_X f(x,y)$.
болохыг тус тус батал.

1.4.

$X \subset R^n$ олонлог дээр тодорхойлогдсон f функцийн хувьд $\{k^k\} \subset X,\ \lim\limits_{k\to\infty} x^k = x$ нөхцлөөс $f(x) \leq \lim\limits_{k\to\infty} f(x^k),\ (f(x)) \geq \lim\limits_{k\to\infty} f(x^k)$ нөхцөл мөрдөж байвал түүнийг x цэг дээр доороосоо(дээрээсээ) хагас тасралтгүй гэж ярьдаг.
$f(x) = \begin{cases} 1, & \texttt{хэрэв}\ x > 0 \\ -1, & \texttt{хэрэв}\ x < 0 \end{cases}$ функц доороосоо(дээрээсээ) хагас тасралтгүй болж байхаар 0 цэг дээр тодорхойл.

1.5.

f функц x цэг дээр тасралтгүй байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь тэрээр энэ цэг дээр дээрээсээ болон доороосоо хагас тасралтгүй байх явдал болохыг батал.

1.6.

f функц доороосоо хагас тасралтгүй байх кзайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь $-f$ функц нь дээрээсээ хагас тасралтгүй байх явдал болохыг батал.

1.7.

Хоёр доороосоо хагас тасралтгүй функцуудыг нэмэхэд, доороосоо хагас тасралтгүй функцийг сөрөг биш тоогоор үржихэд доороосоо хагас тасралтгүй функц гарна гэдгийг тус тус батал.

1.8.

$X \subset R^n$ болон $Y \subset R^n$ дурын олонлогууд, $\varphi(x, y)$ функц нь $X \times Y$ дээр тодорхойлогдсон бөгөөд бэхлэгдсэн $\forall y \in Y$ бүрийн хувьд X дээр доороосоо хагас тасралтгүй, бэхлэгдсэн $\forall x \in X$ бүрийн хувьд Y дээр дээрээсээ зааглагдсан байг. Тэгвэл $f(x) = \sup\limits_{Y} \varphi(x, y)$ функц нь X дээр доороосоо хагас тасралтгүй гэж батал.

1.9.

Дараах Веирштрассын өргөтгөсөн теоремыг батал. X нь R^n дээрх компакт, f нь X дээр доороосоо хагас тасралтгүй функц байг. Тэгвэл f ын X дээрх глобаль минимумын цэг нь оршин байна.

1.10.

X нь R^n дээрх дурын олонлог, Y нь R^m дээрх компакт, $\varphi(x, y)$ нь $X \times Y$ дээр тасралтгүй(доороосоо хагас тасралтгүй) функц байг. $f(x) = \min\limits_{Y} \varphi(x, y)$ функц нь X дээр тасралтгүй (доороосоо хагас тасралтгүй) байна гэж батал.

1.11.

X нь R^n дээрх дурын олонлог, Y нь R^m дээрх компакт, $\varphi(x, y)$ нь $X \times Y$ дээр тасралтгүй функц байг. Бэхлэгдсэн $\forall x \in X$ хувьд $\varphi(x, y)$ функц нь Y дээр глобаль минимумдаа цорын ганц $y(x)$ цэг дээр хүрдэг гэж үзье. $y(x)$ функц нь X дээр тасралтгүй гэж батал.

1.12.

Тоон дараалал $\{a_k\}$ нь үл буурах, ө.х. $\forall k$ хувьд $a_k \le a_{k+1}$ байг. $\lim\limits_{k \to \infty} a_k = \sup\limits_{k} a_k$ болохыг батал.

1.13.

X нь R^n дээрх дурын олонлог, f_k $(k = 1, 2, \dots)$ үүд нь X дээр $\forall x \in X$-ийн хувьд $f_k(x)$ дараалал нь үл буурах гэсэн нөхцлийг хангадаг функцууд байг. Тэгвэл
а. $\lim\limits_{k \to \infty} \sup\limits_{X} f_k(x) = \sup\limits_{X} \lim\limits_{k \to \infty} f_k(x)$
б. хэрэв $f_k(k = 1, 2, \dots)$ функцууд нь X дээр доороосоо хагас тасралтгүй бөгөөд $\forall x \in X$ хувьд $\{f_k(x)\}$ дараалал нь дээрээсээ зааглагдсан бол $f(x) = \lim\limits_{k \to \infty} f_k(x)$ функц нь X дээр доороосоо хагас тасралтгүй гэдгийг тус тус батал.

1.14.

X нь R^n дээрх компакт, $f_k(k=1,2,\dots)$ үүд нь $\forall x\in X$ хувьд $\{f_k(x)\}$ дараалал нь үл буурах, дээрээсээ зааглагдсан нөхцлийг хангах X дээр доороосоо хагас тасралтгүй функцууд байг. Түүнчлэн x^k нь $f_k(x)$ функцийн X дээрх глобаль минимумын цэг, $\bar{x}$ нь $\{x^k\}$ дарааллын дурын хязгаарын цэг байг.
а. $\lim\limits_{k\to\infty}\min\limits_X f_k(x)=\min\limits_X\lim\limits_{k\to\infty} f_k(x)$;
б. $\bar{x}$ нь $f(x)=\lim\limits_{k\to\infty} f_k(x)$ функцийн X олонлог дээрх глобаль минимумын цэг
болохыг тус тус батал.

1.15.

$X_\beta=\{x\in X|\ f(x)\le\beta\},\ \beta\in R$ олонлогийг f функцийн $X\subset R^n$ олонлог дээрх Лебегийн олонлог гэнэ. Дараах өгүүлбэрүүдийг батал.
а. хэрэв X битүүбөгөөд f нь X дээр доороосоо хагас тасралтгүй бол бүх X_β олонлогууд нь битүү.
б. хэрэв бүх X_β олонлогууд нь битүү бол f нь X дээр доороосоо хагас тасралтгүй байна.

1.16.

Дараах Вейрштрассын өргөтгөсөн теоремыг батал.
X нь R^n дээрх битүү олонлог, f нь X дээр доороосоо хагас тасралтгүй функц бөгөөд түүний ямар нэгэн Лебегийн олонлог X_β нь хоосон биш, зааглагдсан байг. Тэгвэл f ын X дээрх глобаль минимумын цэг нь оршин байна.

1.17.

Төгсгөлгүй өсдөг функцийн бүх Лебегийн олонлогууд нь зааглагдсан байна гэдгийг батал.

1.18.

Теорем 1.2. ын дараах өргөтгөлийг батал.
X нь R^n дээрх дурын олонлог, f нь X дээр төгсгөлгүй өсдөг, доороосоо хагас тасралтгүй функц байг. Тэгвэл f функцийн X дээрх глобаль минимумын цэг оршин байна.

1.19.

Теорем 1.3. ыг батал.

1.20.

Теорем 1.4. ыг батал.

1.21.

X нь R^n дээрх зааглагдсан олонлог, f функц нь $\bar{X}$ гүйцээлт дээр тасралтгүй бөгөөд X дээр дифференциалчлагддаг байг. $\forall x\in\bar{X}\backslash X$ хувьд $h\in R^n$ гэсэн вектор орших бөгөөд хангалттай бага бүх $\alpha>0$ хувьд $x+\alpha h\in X$ бөгөөд $\overline{\lim\limits_{\alpha\to 0+}} < f'(x+\alpha h), h >< 0$ нөхцлүүдийг хангадаг байг. (f' нь тухайн уламжлалудаар зохиосон вектор). f функцийн X олонлог дээрх глобаль минимумын цэг оршин байна гэдгийг батал.

1.22.

$f_1(\alpha), f_2(\alpha), \ldots, f_n(\alpha)$ нь тоон аргументтэй функцууд бөгөөд $\alpha \geq 0$ үед тасралтгүй, $\alpha > 0$ үед тасралтгүй дифференциалчлагддаг бөгөөд $\lim\limits_{\alpha \to 0+} f_j'(\alpha) = -\infty,\ (j = 1, 2, \ldots, n)$ байг. Тэгвэл $f(x) = \sum\limits_{j=1}^{n} f_j(x_j)$ функцийн $X = \{x \in R^n |\ \sum\limits_{j=1}^{n} x_j = 1,\ x_j > 0,\ j = 1, 2, \ldots, n\}$ олонлог дээрх глобаль минимум оршин байна гэдгийг батал.

1.23.

Тасралтгүй функц f нь R^n дээр глобаль минимумын цэгтэй байг. Эндээс f нь дурын битүү $X \subset R^n$ гэсэн олонлог дээр f глобаль минимумдаа хүрнэ гэж мөрдөж гарах уу?

1.24.

Тасралтгүй функцууд f болон g-үүд нь $X \subset R^n$ битүү олонлог дээр глобаль минимумын цэгүүдтэй байг. Эндээс $f + g$ нь X дээр мөн глобаль минимумдаа хүрнэ гэж мөрдөж гарах уу?

1.25.

$f(x) = (a+1)x + a \ln x - 2 \sin x$ функц эерэг тоонуудын олонлог дээр глобаль минимумын цэгтэй байх a параметрийн бүх утгуудыг ол.

1.26.

$f(x, y) = (a-2)(a-3)\exp^x + \frac{|y+10|}{y^2+1}$ функц $X = \{(x, y) | (a-4)x^2 + y^2 \leq 1\}$ олонлог дээр глобаль минимумын цэгтэй байх a параметрийн бүх утгуудыг ол. Түүнчлэн $f^* = \inf\limits_{X} f(x, y)$ утга төгслөг боловч энэ утганд хүргэх цэг олддоггүй байх a параметрийн бүх утгуудыг ол.

1.27.

$f(x, y) = x + ay$ функц $X = \{(x, y) | bx^2 - 2xy + y^2 \leq 1\}$ олонлог дээр глобаль минимумын цэгтэй байх a болон b параметрүүдийн бүх утгуудыг ол.

1.28.

$f(x, y) = 4x^2 + (a-4)xy^2$ функц $X = \{(x, y) | (a-1)x + y^2 \leq 1\}$ олонлог дээр глобаль минимумын цэгтэй байх a параметрийн бүх утгуудыг ол.

1.29.

$(1, 3, 8)$ цэгийн $X = \{(x, y, z) | 0 \leq x \leq 2,\ 4 \leq y \leq 5,\ 6 \leq z \leq 7\}$ параллелепипед дээрх проекцийг ол.

1.30.

(x_0, y_0) цэгийн $X = \{(x, y) | ax + by = 1,\ x \geq 0,\ y \geq 0\},\ a > 0,\ b > 0$ олонлог дээрх проекцийг ол.

1.31.

(x_0, y_0) цэгийн $X = \{(x, y) | x^2 + y^2 \geq 1,\ y \geq 0$ олонлог дээрх бүх проекцийг ол. Дараах бодлогуудын глобаль шийдүүдийг ол. (Өгөгдсөн тэгшитгэл, тэнцэтгэл бишүүд нь боломжит шийдийн мужийг дүрсэлнэ.)

1.32.

$f(x, y) = xy \to \max,\ ax + by = 1$, энд $a > 0,\ b > 0$.

1.33.

$f(x, y) = -\ln x + y \to \min,\ x - y \leq 2,\ x + y^2 \leq 4,\ x > 0$.

1.34.

$f(x, y) = 2x - y \to \max,\ x^2 + y^2 \leq 1,\ x - y \leq 0,\ x + y \leq 1$.

1.35.

$f(x, y) = x + \sqrt{y} \to \min,\ x + y \geq 1,\ x^2 + y^2 = 1$.

1.36.

$f(x, y) = \max\{|x - 2|,\ |y|\} \to \min,\ 2|x| - |y| \leq 2$.

1.37.

$f(x, y) = (x - 1)^2 + y^2 \to \min,\ x^2 + y^2 = 2axy$, энд $a \in R$.

1.38.

$f(x, y) = 4x^2 + y^2 \to \max(\min),\ |x - 3| + |y - a| \leq 1$, энд $a \geq 0$.

1.39.

$x^3 + y^3 \to \max,\ x^2 + 4y^2 \leq 4$ бодлогын локаль шийдийг ол.

1.40.

a параметрийн ямар утганд дараах бодлого глобаль шийдтэй, ямар утганд локаль шийдтэй байх вэ? $x + ay \to \max,\ x^3 + y^3 = 3xy$

1.41.

$2x + y \to \max,\ x^2 - y^2 \leq 1,\ 0 \leq y \leq ax + 1$ бодлого глобаль шийдтэй байх a параметрийн бүх утгуудыг ол. Энэхүү бүлгийн сүүлчийн 3 бодлого нь максимумын аксиоматик тодорхойлолтын тухай Кукушкины теоремд зориулагдсан болно.

1.42.

X нь R^n дээрх компакт, $C(X)$ нь X дээрх бүх тасралтгүй функцуудын олонлог, F нь $C(X)$ дээр тодорхойлогдсон функциональ байг. F нь дараах хоёр аксиомыг хангана гэж үзье.
1) $F(\alpha f+\beta)=\alpha F(f)+\beta,\ \forall f\in C(X),\ \alpha,\beta\in R,\ \alpha>0;$
2) $F(\max\{f,g\})=\max\{F(f),F(g)\},\ \forall f,g\in C(X).$
Тэгвэл
а. $F(\beta)=\beta,\ \forall\beta\in R;$
б. F функциональ үл буурах, ө.х. хэрэв $f(x)\le g(x),\ \forall x\in X$ бол $F(f)\le F(g)$.
в. $\min\limits_X f(x)\le F(f)\le\max\limits_X f(x),\ \forall f\in C(X)$. болохыг тус тус батал.

1.43.

Өмнөх бодлогын хувьд F функционалийн хувьд дараах олонлогуудыг харгалзуулан оруулъя.
$E_f=\{x\in X|f(x)\le F(f)\},\ f\in C(X)$
$E=\bigcap\limits_{f\in C(X)} E_f.$
Тэгвэл
а. Дурын $Y\subset X,\ Y\cap E=\emptyset$ гэсэн битүү олонлогийн хувьд $\min\limits_Y f(x)>F(f)$ тэнцэтгэл бишийг хангах $f\in C(X)$ функц олдоно;
б. E хоосон биш, битүү олонлог;
в. $\max\limits_E f(x)\le F(f),\ \forall f\in C(X)$ болохыг тус тус батал.

2 бүлэг. Нөхцөлт биш оптимизацийн бодлого

2.1 Экстремумын нөхцөл

$$f(x)\to\min,\ x\in R^n. \tag{2.1}$$

гэсэн нөхцөлт биш экстремумын бодлого өгсөн байг. $f'(x)=(\frac{\partial f}{\partial x_1}(x),\dots,\frac{\partial f}{\partial x_n}(x))$ нь f функцийн нэгдүгээр эрэмбийн тухайн уламжлалуудаас зохиосон вектор(градиент), $f''(x)=(\frac{\partial^2 f}{\partial x_i\partial x_j}(x))_{i,j=1,\dots,n}$ f функцийн хоёрдугаар эрэмбийн тухайн уламжлалуудаас зохиосон матриц(гессиан).

Теорем 2.1(нэгдүгээр эрэмбийн зайлшгүй нөхцөл) f функц нь $x^*\in R^n$ цэг дээр дифференциалчлагддаг байг. Тэгвэл хэрэв x^* нь (2.1.) бодлогын локаль шийд бол

$$f'(x^*)=0 \tag{2.2}$$

байна. (2.2) нөхцлийг хангаж байгаа $x^*\in R^n$ цэгүүдийг (2.1) бодлого болон f функцын стационар цэгүүд гэнэ.

Теорем 2.2(хоёрдугаар эрэмбийн зайлшгүй нөхцөл) f функц нь $x^*\in R^n$ цэг дээр 2 удаа дифференциалчлагддаг байг. Тэгвэл хэрэв x^* нь (2.1.) бодлогын локаль шийд бол $f''(x^*)$ матриц нь сөрөг биш тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл,

$$<f''(x^*)h,h>\ge 0,\ \forall h\in R^n. \tag{2.3}$$

байна.

Теорем 2.3(минимумын хоёрдугаар эрэмбийн хүрэлцээтэй нөхцөл) f функц нь $x^* \in R^n$ цэг дээр 2 удаа дифференциалчлагддаг байг. Тэгвэл хэрэв

$$f'(x^*) = 0$$

бөгөөд $f''(x^*)$ матриц эерэг тодорхойлогдсон. Өөрөөр хэлбэл,

$$< f''(x^*)h, h >> 0, \ \forall h \in R^n, h \neq 0. \tag{2.4}$$

бол x^* нь (2.1.) бодлогын эрс локаль шийд байна.

2.2 Дифференциалчлагддаг буулгалт.

$F = (F_i) : X \to R^m, \ X \subset R^n$ буулгалтын(вектор функц) хувьд $F'(x)$ гэдгээр F-ын $x \in X$ цэг дээрх тухайн уламжлалуудын

$$F'(x) = (\frac{\partial F_i}{\partial x_j}(x))_{i=1,\dots,m, \quad j=1,\dots,n}$$

гэсэн матрицыг ойлгоно. Энд i нь мөрийн индекс, j нь баганын индекс. Энэхүү матрицыг F буулгалтын x цэг дээрх Якобийн матриц гэдэг. Хэрэв $F_i, \ i = 1, \dots, m$ функц бүр X дээр дифференциалчлагддаг (тасралтгүй дифференциалчлагддаг) бол $F = (F_i) : X \to R^m$ буулгалтыг дифференциалчлагддаг (тасралтгүй дифференциалчлагддаг) гэнэ. Ийнхүү F-ын тасралтгүй дифференциалчлагдалт нь $F'(x)$ матрицын оршин байх болон X дээр тасралтгүй байхтай тэнцүү чанартай байна. Харин $F : X \times Y \to R^k, \ X \subset R^n, \ Y \subset R^m$ буулгалтын хувьд $F'_x(x^*, y^*)$ оор түүний x координатаархи Якобийн матрицын $(x^*, y^*) \in X \times Y$ дээрх утга $F'_x(x^*, y^*) = (\frac{\partial F_i}{\partial x_j}(x^*, y^*))_{i=1,\dots,k, \quad j=1,\dots,n}$ ыг ойлгоно. Дараах математик анализийн үндсэн теорем нь энэ болон дараагийн бүлгийн зарим бодлогуудыг бодоход хэрэглэгдэнэ.

Теорем 2.4(далд функцийн тухай) $X \subset R^n, \ Y \subset R^m$ үүд нь задгай олонлогууд, $F : X \times Y \to R^n$ нь тасралтгүй дифференциалчлагддаг буулгалт, $x^* \in X, \ y^* \in Y$ байг. $F(x^*, y^*) = 0$ бөгөөд $F'_x(x^*, y^*)$ матриц нь үл бөхөх гэж үзье. Тэгвэл x^* ын U болон y^* ын V гэсэн орчингууд дараах чанаруудыг хангаж байхаар олдоно:
$\forall y \in V$ ын хувьд $F(x(y), y) = 0$ нөхцлийг хангах $x(y) \in U$ цэг цорын ганц олдоно. Энэхүү $x(y^*) = x^*$ ын хувьд вектор функц $x(y)$ нь V дээр тасралтгүй дифференциалчлагдах бөгөөд

$$x'(y^*) = -[F'_x(x^*, y^*)]^{-1} F'_y(x^*, y^*).$$

Түүнчлэн давхар функцийн дифференциалчлах дүрмийг санавал: хэрэв $F : X \to Y$ ба $G : Y \to R^k$, $X \subset R^n, \ Y \subset R^m$ буулгалтууд нь дифференциалчлагддаг бол $H : X \to R^k$ гэсэн $H(x) = G(F(x))$, буулгалт дифференциалчлагдах бөгөөд $H'(x) = G'(y)F'(x), \ y = F(x)$ байна. Энд Якобийн матрицууд $H'(x), \ G'(y)$ болон $F'(x)$ үүд нь харгалзан $k \times n, \ k \times m, \ m \times n$ хэмжээсүүдтэй байна.

Дасгал

2.1.

$f(x, y) = ax^2 + 2xy + by^2 - 2x - 3y$ функцийн глобаль минимумыг R^2 хавтгай дээр ол.

Хүснэгт 2.1.

	a	b		a	b		a	b		a	b
1	1	2	6	2	1	11	3	1	16	4	1
2	1	3	7	2	2	12	3	2	17	4	2
3	1	4	8	2	3	13	3	3	18	4	3
4	1	5	9	2	4	14	3	4	19	4	4
5	1	6	10	2	5	15	3	5	20	4	5

2.2.

$f(x, y) = axy + \frac{b}{x} + \frac{c}{y} \to \min, \ x > 0, \ y > 0$ бодлогын глобаль шийд болон утгыг ол.

Хүснэгт 2.2.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	1	3	6	3	4	1	11	4	1	1	16	2	3	3
2	3	2	4	7	2	1	4	12	1	4	1	17	1	1	4
3	1	2	3	8	4	1	2	13	2	4	3	18	1	1	1
4	3	1	2	9	4	1	3	14	3	4	2	19	3	1	3
5	2	3	1	10	4	2	3	15	1	3	4	20	3	1	4

2.3.

$f(x, y) = x^2 + xy + ay^2 - b \ln x - c \ln y \to \min, \ x > 0, \ y > 0$ бодлогын глобаль шийдийг ол.

Хүснэгт 2.3.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	3/2	2	1	6	7/3	3	2	11	1/8	8	6	16	7/4	4	1
2	1/2	3	2	7	2/3	3	1	12	4	3	1	17	5/2	4	1
3	5/2	2	1	8	2	3	1	13	3/2	4	2	18	1	5	2
4	1/6	6	5	9	3/4	4	2	14	4/5	5	3	19	3/5	5	1
5	7	2	1	10	2/5	5	3	15	1/2	6	4	20	2/3	6	2

2.4.

$f(x, y) = \exp -(x^2 + y^2)(ax^2 + by^2)$ функцийн R^2 дээрх экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 2.4.

	a	b		a	b		a	b		a	b
1	1	2	6	8	3	11	9	1	16	4	1
2	7	3	7	2	4	12	3	5	17	6	7
3	1	4	8	2	5	13	3	1	18	4	3
4	8	5	9	7	6	14	7	2	19	1	5
5	1	6	10	2	7	15	3	6	20	5	6

2.5.

$f(x,y) = \frac{ax+by+c}{\sqrt{x^2+y^2+1}}$ функцийн R^2 дээрх экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 2.5.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	4	-1	2	6	1	3	-4	11	-2	4	1	16	2	3	3
2	4	2	-1	7	-1	3	4	12	4	-2	-1	17	3	1	4
3	1	2	4	8	2	5	2	13	6	1	6	18	6	-1	-2
4	3	1	2	9	1	3	-3	14	6	1	-6	19	1	5	4
5	3	-1	-2	10	2	1	3	15	4	6	-1	20	1	-1	-4

2.6.

$f(x,y) = ax^3 + ax^2y + bx + \frac{1}{3}y^3 + cy$ функцийн R^2 дээрх экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 2.6.

	a	b	c		a	b	c
1	-5/4	-5/2	-11/2	11	-2	-2	-17/8
2	-5/4	5/2	1/2	12	-2	2	7/8
3	-5/4	-10	-22	13	-2	-8	-17/2
4	-5/4	10	2	14	-2	8	7/2
5	-5/4	-5	-11	15	-2	-4	-17/4
6	-5/4	5	1	16	-2	4	7/4
7	-5/4	-5/2	-19/2	17	-2	-2	-7/3
8	-5/4	5/2	-1/3	18	-2	2	2/3
9	-5/4	-15/2	-19	19	-2	-6	-7
10	-5/4	15/2	-1	20	-2	6	2

2.7.

$f(x,y) = x^3y^2(ax+by+c)$ функцийн R^2 дээрх экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 2.7.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	-4	-1	1	6	-2	-1	3	11	-5	-1	5	16	-3	-1	7
2	-3	-1	9	7	-4	1	2	12	-1	1	2	17	-2	-1	2
3	-1	1	3	8	-2	-1	8	13	-1	-1	9	18	-9	1	3
4	-5	-1	4	9	-4	-1	4	14	-3	1	8	19	-2	-1	1
5	-1	-1	7	10	-2	1	6	15	-4	1	5	20	-2	1	9

2.8.

$(0,1)$ цэг нь $f(x,y) = k^3 x \exp y - k^2 a \ln(x + \frac{a-3}{a}y) + ((a+b-1)k - b)x + kcy + 2bxy$ функцийн экстремаль болж байх k параметрийн бүх утгыг тодорхойлж, экстремалийн шинж чанарыг тайлбарла.

Хүснэгт 2.8.

	a	b	c		a	b	c
1	5/2	1/2	-5/2	11	2	-2	-4
2	3/2	-1/2	-3/2	12	3/2	-3	-4
3	-1/2	1/2	7/2	13	1	-4	-4
4	-2	2	8	14	-7/2	5	14
5	-5/2	5/2	19/2	15	-4	6	16
6	-3	3	11	16	7/2	-3/2	-13/2
7	-4	4	14	17	3	-3	-7
8	-5	5	17	18	2	-6	-8
9	-6	6	20	19	5/2	-9/2	-15/2
10	5/2	-1	-4	20	1	-9	-9

Бодлого

2.1.

(2.1)-(2.3) теоремуудыг батал.

2.2.

а. Тоон аргументтэй f функц нь x^* цэг дээр тасралтгүй бөгөөд $U = (x^* - \varepsilon, x^* + \varepsilon)$ интервалын үлдсэн x үүд дээр дифференциалчлагддаг байг. $\begin{cases} f'(x) \leq 0, & x^* - \varepsilon < x < x^* \\ f'(x) \geq 0, & x^* < x < x^* + \varepsilon \end{cases}$ гэж үзье. Тэгвэл x^* нь f функцийн U олонлог дээрх минимумын цэг гэж батал.
б. x^* нь f дифференциалчлагддаг функцийн R тоон тэнхлэг дээрх эрс локаль минимумын Дараах функцуудын локаль болон глобаль экстремумын цэгүүдийг тэдгээрийн тодорхойлогдох муж дээр ол.

2.3. $f(x, y, z) = x^2 + 2y^2 + 5z^2 - 2xy - 4yz - 2z.$

2.4. $f(x, y) = a \exp^{-x} + b \exp^{-y} + \ln(\exp^x + \exp^y)$, *энд* $a > 0,\ b > 0.$

2.5. $f(x, y) = x^4 + y^4 - 4xy.$

2.6. $f(x, y) = (x + y)(x - a)(y - b).$

2.7. $f(x, y) = x^2 - 2xy^2 + y^4 - y^5.$

2.8. $f(x, y) = x + y + 4 \sin x \sin y.$

2.9. $f(x, y) = x \exp^x - (1 + \exp^x) \cos y.$

2.10. $f(x, y, z) = x^3 + y^2 + z^2 + 12xy + 2z.$

2.11. $f(x, y, z) = xy^2z^3(1 - x - 2y - 3z).$

Дараах бодлогуудын глобаль шийдийг ол.

2.12. $f(x,y,z) = x + \frac{y^2}{4x} + \frac{z^2}{y} + \frac{2}{z} \to \min, \quad x > 0,\ y > 0,\ z > 0.$

2.13. $f(x,y) = x^2 + y + \frac{1}{x+y} \to \min, \quad x + y > 0.$

2.14.

x^* нь дифференциалчлагддаг функц f-ийн R дээрх цорын ганц стационар цэг бөгөөд локаль минимумын цэг болдог байг. Тэгвэл энэхүү цэг мөн глобаль минимумын цэг болно гэж батал.

2.15.

R^2 дээр яг нэг стационар цэгтэй бөгөөд тэр нь локаль минимумын цэг болоод глобаль минимумын цэг болдоггүй дифференциалчлагддаг функцийн жишээ байгуул.

2.16.

R^2 дээр яг m ширхэг стационар цэгтэй бөгөөд тэдгээр нь бүгдээрээ локаль минимумын цэг байдаг дифференциалчлагддаг функцийн жишээ байгуул.

2.17.

R^2 дээр тэгш тооны стационар цэгтэй бөгөөд тэдгээр нь бүгдээрээ локаль минимумын цэг байдаг дифференциалчлагддаг функцийн жишээ байгуул.

3 бүлэг. Нөхцөлт экстремумын сонгодог бодлого

3.1 Үндсэн ойлголтууд

$X = \{x \in R^n | g_i(x) = 0,\ i = 1, \dots, m\}$ гэсэн төгслөг тооны тэгшитгэлүүдийн системээр өгөгдсөн X олонлог дээр f функцийг минимумчлах (эсвэл максимумчлах) бодлогыг нөхцөлт экстремумын сонгодог бодлого гэнэ. Энэхүү бодлогыг

$$f(x) \to \min,\ g_i(x) = 0,\ i = 1, \dots, m \tag{3.1}$$

гэсэн хэлбэрээр бичье. Хувьсагчийг зайлуулах аргаар шийдийг хайж болно. Боломжит шийдийн олонлог нь n үл мэдэгдэгчтэй, m тэгшитгэлүүдийн системээс тогтож байгаа бөгөөд энэ дүрмээр $m < n$ байна. $x = (u, v) \in R^m \times R^{n-m}$ болон $\forall v \in R^{n-m}$ ын хувьд

$$g_i(u, v) = 0,\ i = \ 1, \dots, m$$

гэсэн m хувьсагчтай m тэгшитгэлүүдийн систем нь $u = u(v)$ гэсэн цорын ганц шийдтэй байг. Тэгвэл (3.1) бодлого нь нөхцөлт биш минимумчлалын дараах бодлого руу шилжинэ.

$$F(v) = f(u(v), v) \to \min,\ v \in R^{n-m}. \tag{3.2}$$

Хэрэв v^* нь энэхүү бодлогын локаль(глобаль) шийд бол мэдээж $(u(v^*), v^*)$ нь (3.1) бодлогын локаль(глобаль) шийд байх бөгөөд урвуу нь хүчинтэй. Нэгэн утгатай функц $u(v)$ нь үргэлж оршдоггүй тул энэхүү хувьсагчийг зайлуулах аргын хэрэглээ нь хязгаарлагдмал байдаг. Түүнээс гадна (3.1) бодлогын хувьд экстремумын нөхцлийг шууд ашигладаг илүү боловсронгүй арга байдаг бөгөөд энэ нь Лагранжийн арга гэдэг. Нөхцөлт экстремумын (3.1) бодлогын хувьд Лагранжийн функцийг бичье:

$$L(x, \lambda_0, \lambda) = \lambda_0 f(x) + \sum_{i=1}^{m} \lambda g_i(x),$$

Үүнд $x \in R^n,\ \lambda 0 \in R,\ \lambda = (\lambda 1, \ldots, y_m) \in R^m$ байна. Лагранжийн функцийн x ээрх градиент:

$$L'_x(x, \lambda_0, \lambda) = \lambda_0 f'(x) + \sum_{i=1}^{m} \lambda g'_i(x)$$

. Лагранжийн функцийн x ээрх гессиан:

$$L''_x(x, \lambda_0, \lambda) = \lambda_0 f''(x) + \sum_{i=1}^{m} \lambda g''_i(x)$$

. Лагранжийн функц дээр үндэслэгдсэн дараах теорем нь нөхцөлт экстремумын сонгодог онолын үндэс болдог.

Теорем 3.1(1-р эрэмбийн зайлшгүй нөхцөл буюу Лагранжийн зарчим) f функц нь $x^* \in R^n$ цэг дээр дифференциалчлагддаг бөгөөд $g_1, \ldots, g_m$ функцууд нь энэхүү цэгийн ямар нэгэн орчинд тасралтгүй дифференциалчлагддаг байг. Тэгвэл хэрэв x^* нь (3.1) бодлогын локаль шийд бол нэгэн зэрэг тэгтэй тэнцүү биш λ_0^* тоо болон $\lambda^* \in R^m$ вектор нь

$$L'_x(x^*, \lambda_0^*, \lambda^*) = 0, \tag{3.3}$$

нөхцлийг хангаж байхаар олдоно. $x^* \in X$ цэг нь ямар нэгэн нэгэн зэрэг тэг биш $\lambda_0^* \geq 0$ тоо болон $\lambda^* \in R^m$ векторын хувьд (3.4) ыг хангаж байвал түүнийг (3.1) бодлогын стационар цэг гэнэ. Энэ тохиолдолд $\lambda_0^*, \lambda_1^*, \ldots, \lambda_m^*$ тоонуудыг x^* д харгалзах Лагранжийн үржигдэхүүнүүд гэнэ. (3.4) тэнцэтгэл нь $x^* \in X$ нөхцлийн хамтаар $n + m + 1$ үл мэдэгдэгчтэй $n+m$ тэгшитгэлүүдийн системийг үүсгэнэ. Иймд үргэлж $n+m$ хувьсагчтай системд шилжиж болох ба $\lambda_0^* = 0$ эсвэл $\lambda_0^* = 1$ гэсэн хоёр тохиолдлыг ямагт авч үздэг. Лагранжийн регуляр функц дараах хэлбэртэй:

$$L(x, y) = L(x, 1, \lambda) = f(x) + \sum_{i=1}^{m} \lambda g_i(x),$$

Теорем 3.2(2-р эрэмбийн зайлшгүй нөхцөл) $f, g_1, \ldots, g_m$ функцууд нь $x^* \in R^n$ цэг дээр хоёр удаа дифференциалчлагддаг байг. Түүнчлэн $g_1, \ldots, g_m$ функцууд нь x^* цэгийн ямар нэг орчинд тасралтгүй дифференциалчлагддаг бөгөөд тэдгээрийн градиентууд $g'_1(x^*), \ldots, g'_m(x^*)$ нь шугаман хамааралгүй байг. Тэгвэл хэрэв x^* нь (3.1) бодлогын локаль шийд бол (3.4)-ийг хангах бүх $\lambda_0^* > 0,\ \lambda^* \in R^m$ болон

$$< g'_i(x^*), h >= 0,\ i = 1, \ldots, m \tag{3.4}$$

нөхцлийг хангах бүх $h \in R^n$ -ийн хувьд

$$< L''_x(x^*, \lambda_0^*, \lambda^*)h, h > \geq 0 \qquad (3.5)$$

байна.

Теорем 3.3(2-р эрэмбийн хүрэлцээтэй нөхцөл) $f, g_1, \dots, g_m$ функцууд нь $x^* \in X$ цэг дээр хоёр удаа дифференциалчлагддаг байг. Тэгвэл хэрэв (3.4)-ийг хангах $\lambda_0^* \geq 0$ болон $\lambda^* \in R^m$ олдоод (3.6)-г хангах бүх $h \neq 0$-ийн хувьд

$$< L''_x(x^*, \lambda_0^*, \lambda^*)h, h >> 0 \qquad (3.6)$$

нөхцөл биелдэг бол x^* нь (3.1) бодлогын эрс локаль шийд байна.

Дасгал

3.1.

Дараах бодлогыг эхлээд хувьсагчийг зайлуулах аргаар, дараа нь Лагранжийн аргаар бод.

$$xy^3 \to \max, \quad ax + by = c$$

Хүснэгт 3.1.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	3	7	6	2	5	6	11	3	1	10	16	6	2	4
2	1	5	8	7	1	4	8	12	1	5	10	17	6	2	8
3	3	1	6	8	3	5	7	13	2	7	10	18	8	2	5
4	2	4	9	9	4	3	6	14	4	4	8	19	8	2	10
5	4	1	6	10	1	6	9	15	4	2	12	20	8	3	11

3.2.

$x^2 + y^2 = c^2$ гэсэн нөхцөлд $f(x, y) = ax + by$ функцийн экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 3.2.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	-3	5	6	7	2	4	11	-2	-5	5	16	5	1	3
2	4	1	3	7	-2	6	2	12	5	-3	1	17	-1	5	1
3	-3	4	2	8	-1	7	5	13	-5	-1	2	18	2	5	2
4	-2	1	1	9	-4	-1	3	14	-7	-1	4	19	-5	3	5
5	2	3	4	10	-2	-3	1	15	1	-7	3	20	1	7	4

3.3.

$4x^2 + cy^2 = 9$ гэсэн нөхцөлд $f(x, y) = ax^2 + 2xy + by^2$ функцийн экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 3.3.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	1	1	3	6	3	2	2	11	5	8	6	16	7	4	2
2	3	4	5	7	5	4	3	12	5	3	2	17	13	4	1
3	1	1	2	8	3	5	6	13	9	3	1	18	7	11	6
4	1	2	6	9	7	9	5	14	9	7	3	19	9	5	2
5	1	1	1	10	5	2	1	15	3	6	7	20	7	13	7

3.4.

$x^2 + y^2 = c^2$ гэсэн нөхцөлд $f(x, y) = ax^3 + by^3$ функцийн экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 3.4.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	3	2	2	6	3	1	3	11	1	8	1	16	2	3	4
2	7	3	3	7	4	3	4	12	4	1	5	17	2	7	1
3	1	2	5	8	1	4	5	13	5	3	4	18	8	1	2
4	7	2	1	9	5	2	2	14	2	5	3	19	1	3	5
5	3	4	2	10	3	5	1	15	2	1	2	20	3	7	3

3.5.

$ax^3 + by^3 - 3cxy = d$ гэсэн нөхцөлд $f(x, y) = y^2$ функцийн экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 3.5.

	a	b	c	d		a	b	c	d		a	b	c	d		a	b	c	d
1	9	2	9	-16	6	12	1	6	-16	11	-1	2	1	-4	16	-7	16	7	-2
2	-36	1	9	8	7	1	2	1	4	12	-4	1	2	-16	17	28	1	7	8
3	-9	2	9	16	8	4	1	2	16	13	-18	4	9	4	18	1	2	1	12
4	7	2	7	16	9	-7	2	7	-16	14	9	16	9	-2	19	1	16	2	12
5	3	2	3	-4	10	36	1	9	-8	15	14	4	7	4	20	1	1	1	3

3.6.

$ax + by + c^2z^2 = \frac{3}{2}$ гэсэн нөхцөлд $f(x, y, z) = a^2x^2 + b^2y^2 + cz + 2(abxy + bcyz + acxz)$ функцийн экстремумын цэгүүдийг ол.

Хүснэгт 3.6.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	-5	1	-2	6	6	-1	1	11	5	-4	1	16	6	3	-5
2	1	-4	5	7	1	5	-2	12	-4	2	3	17	-1	7	1
3	-6	5	4	8	-3	2	4	13	1	6	-3	18	5	2	-4
4	1	2	-3	9	-5	2	-5	14	-3	-5	4	19	-3	7	5
5	3	-4	2	10	3	-6	3	15	6	4	-5	20	5	3	-2

3.7.

R^4 огторгуйд координатын эхийн

$$X = \{x \in R^4 | \ x_1 + ax_2 - x_4 = b, \ x_1 + ax_3 + x_4 = c\}$$

олонлог дээрх проекцийг ол.

Хүснэгт 3.7.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	2	9	6	6	2	9	-9	11	1	6	6	16	1	6	-9
2	2	9	-6	7	2	-9	9	12	1	6	-6	17	1	-6	9
3	2	-9	6	8	2	-9	-9	13	1	-6	6	18	1	-6	-9
4	2	-9	-6	9	2	9	18	14	1	-6	-6	19	1	6	12
5	2	9	9	10	2	9	-18	15	1	6	9	20	1	6	-12

3.8.

$x^4 e^y + y^2 e^x = 1$ нөхцөлд $(0, 1)$ цэг нь

$$f(x, y) = \ln(ax + 2k^2 y) - kbxy + \frac{b}{k}x + cy$$

функцийн экстремумын цэг болж байх k параметрийн бүх утгыг олж, экстремумын шинж чанарыг тодорхойл.

Хүснэгт 3.8.

	a	b	c		a	b	c		a	b	c		a	b	c
1	4	4	3	6	3	3	2	11	2	2	1	16	1	1	0
2	4	-4	3	7	3	-3	2	12	2	-2	1	17	1	-1	0
3	4	-1	3	8	3	-3/4	2	13	2	-1/2	1	18	1	-1/3	0
4	4	1	3	9	3	3/4	2	14	2	1/2	1	19	1	1/3	0
5	4	-2/3	3	10	3	-1/2	2	15	2	-1/3	1	20	1	-1/6	0

Бодлого

Дараах функцуудын өгөгдсөн хязгаарлалт дахь экстремумын цэгүүдийг ол.

3.1. $f(x, y) = y, \ x^3 + y^3 - 3xy = 0.$

3.2. $f(x, y) = x^3 + y^3, \ ax + by = 1,$ *энд* $a > 0, \ b > 0.$

3.3. $f(x, y) = \dfrac{1}{3}x^3 + y, \ x^2 + y^2 = a,$ *энд* $a > 0.$

3.4. $f(x, y) = x \sin y, \ 3x^2 - 4 \cos y - 1 = 0.$

3.5. $f(x, y, z) = xyz, \ x^2 + y^2 + z^2 = 1, \ x + y + z = 1.$

3.6. $f(x, y, z) = a^2x^2 + b^2y^2 + c^2z^2 - (ax^2 + by^2 + cz^2)^2, \ x^2 + y^2 + z^2 = 1,$ *энд* $a > b > c > 0.$

3.7. $f(x, y, z) = x + y + z^2 + 2(xy + yz + zx), \quad x^2 + y^2 + z = 1.$

Дараах бодлогуудын глобаль шийдүүдийг ол.

3.8. $\prod\limits_{j=1}^{n} x_j^{\alpha_j} \to \max,\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j^{\beta_j} = b,\quad x_j \geq 0,\quad j=1,...,n$ *энд* $\alpha_j > 0,\ \beta_j > 0,\ a_j > 0,\ b > 0.$

3.9. $\sum\limits_{j=1}^{n} c_j x_j^{\alpha_j} \to \min,\ \prod\limits_{j=1}^{n} x_j^{\beta_j} = b,\quad x_j \geq 0,\quad j=1,...,n$ *энд* $c_j > 0,\ \alpha_j > 0,\ \beta_j > 0,\ b > 0.$

3.10. $\sum\limits_{j=1}^{n} \dfrac{c_j}{x_j^{\alpha_j}} \to \min,\ \prod\limits_{j=1}^{n} x_j^{\beta_j} = b,\quad x_j > 0,\quad j=1,...,n$ *энд* $c_j > 0,\ \alpha_j > 0,\ \beta_j > 0,\ b > 0.$

3.11. $\sum\limits_{j=1}^{n} \dfrac{c_j}{x_j^{\alpha}} \to \max,\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j = b,\quad x_j \geq 0,\quad j=1,...,n$ *энд* $c_j > 0,\ \alpha > 0,\ a_j > 0,\ b > 0.$

3.12. $\sum\limits_{j=1}^{n} c_j x_j^{\alpha} \to \max,\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j = b,\quad x_j > 0,\quad j=1,...,n$ *энд* $c_j > 0,\ a_j > 0,\ b > 0,\ 0 < \alpha < 1.$

3.13. $\sum\limits_{j=1}^{n} c_j x_j^{\alpha} \to \min,\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j = b,$ *энд* $c_j > 0,$ α*-тэгш натурал тоо,* $a = (a_1, ..., a_n) \neq 0.$

3.14. $\sum\limits_{j=1}^{n} c_j |x_j|^{\alpha} \to \min,\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j = b,$ *энд* $c_j > 0,\ \alpha > 1,\ a = (a_1, ..., a_n) \neq 0,\ b > 0.$

3.15. $\sum\limits_{j=1}^{n} c_j x_j \to \max(\min),\ \sum\limits_{j=1}^{n} a_j x_j^{\alpha} = b,$ *энд* $c = (c_1, ..., c_n) \neq 0,\ a_j > 0,\ b > 0,$ α*-тэгш натурал тоо.*

3.16. $\sum\limits_{j=1}^{n} c_j x_j \to \max(\min),\ \sum\limits_{j=1}^{n} a_j |x_j|^{\alpha} = b,$ *энд* $c = (c_1, ..., c_n) \neq 0,\ a_j > 0,\ b > 0,\ \alpha > 1.$

3.17. $\sum\limits_{j=1}^{n} |x_j + c_j|^{\alpha} \to \max(\min),\ \sum\limits_{j=1}^{n} |x_j|^{\alpha} = b,$ *энд* $c = (c_1, ..., c_n) \neq 0,\ \alpha > 1,\ b > 0.$

3.18. $\dfrac{1}{2}\sum\limits_{j=1}^{n} x_j^2 \to \min,\ \sum\limits_{j=1}^{n} a_{ij} x_j = b_i,\ \ i = 1, 2,$ *энд* $a_{ij},\ b_i$*-өгөгдсөн тоонууд,* $a_i = (a_{i1}, ..., a_{ij}, ..., a_{in})$ $(i = 1, 2)$ *векторууд нь шугаман хамааралгүй.*

4 бүлэг. Шугаман програмчлал

4.1 Полиэдр болон түүний оройнууд

$H_{ab} = \{x \in R^n |\ < a, x >= b\},\ a \in R^n,\ a \neq 0,\ b \in R$ олонлогийг гипер хавтгай, $H_{ab}^{+} = \{x \in R^n |\ < a, x > \geq b\}, H_{ab}^{-} = \{x \in R^n |\ < a, x > \leq b\}$, олонлогуудыг гиперхавтгайнуудаар төрөгдсөн хагас огторгуйнууд гэж нэрлэнэ.

Хэрэв $X \in R^n$ олонлогийг төгслөг тооны хагас огторгуйнуудын огтлолцол мэтээр тавьж болдог бол түүнийг полиэдр гэнэ.

$$X = \{x \in R^n | Ax \leq b\} = \{x \in R^n | < a_i, x > \leq b_i,\ i = 1, \ldots, m\}, \tag{4.1}$$

Үүнд $A \in\ A(m, n),\ b \in R^m$. $\forall x \in X$ ын хувьд $I(x)$ ээр (4.1) ийн өгсөн цэг дээр тэнцэтгэл болж байдаг тэнцэтгэл бишүүдийн дугааруудын олонлогийг тэмдэглэе.

$$I(x) = \{i,\ 1 \leq i \leq m | < a_i, x >= b_i\} \tag{4.2}$$

Хэрэв $x^* \in X$ болон $a_i,\ i \in I(x^*)$ векторуудаас n шугаман хамааралгүй вектор сонгон авч болдог өөрөөр хэлбэл $rangA_{I(x^*)} = n$ бол x^*-г (4.1) ээр тодорхойлогдох X полиэдрийн орой гэнэ. Өөрөөр хэлбэл $x^* \in R^n$ нь

$$A_{I(x^*)}x = b_{I(x^*)}$$

систем тэгшитгэлүүдийн цорын ганц шийд болж байвал тэрээр X ын орой болно. Иймд x^* нь орой байхын тулд зайлшгүй $|I(x^*)| \geq n$ байх ёстой болно. Хэрэв $|I(x^*)| = n$ бол x^* оройг бөхөөгүй, эсрэг тохиолдолд бөхсөн орой гэнэ.

Терем 4.1 Аливаа полиэдр нь төгслөг тооны оройн цэгүүдтэй байна.

Полиэдр нь оройн цэггүй байж болох бөгөөд үүний жишээ бол хагас хавтгай юм.

Терем 4.2 (4.1) хэлбэртэй X полиедр нь ядаж нэг оройн цэгтэй байх зайлшгүй бөгөөд хүрэлцээтэй нөхцөл нь $rang(A) = n$ юм. Түүнчлэн дээрх нөхцөл биелж байхад $\forall x \in X$ хувьд $I(x) \subset I^*(x)$ байх x^* орой олдоно. $< a, x >= b$ тэнцэтгэл нь $< a, x > \leq b$, $< a, -x > \leq -b$ тэнцэтгэл бишүүдтэй тэнцүү чанартай. Иймд

